

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны дугаар
сарын-ны өдөр

Дугаар.....

Улаанбаатар
хот

Журамд өөрчлөлт оруулах тухай

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.9 дэх хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1.Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 02 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Даатгуулагчид тусламж, үйлчилгээ үзүүлэх сэргээн засах төв болон сувиллыг сонгох, гэрээ байгуулах, санхүүжүүлэх, тусламж, үйлчилгээний чанарт хяналт тавих журам”-ын 3.2 дахь хэсэгт “3.2.11.Магадлан итгэмжлэлийн хүчинтэй хугацаа дуусаагүй байх” гэж нэмэх, 4 дэх хэсгийн 4.1.5 дахь заалтын “гэрчилгээний” гэснийг “батламжийн” гэж, 5.1 дэх хэсгийн “Ажлын хэсэг сонгон шалгаруулалтын урилгад заасан баримт бичгийг хүлээн авах эцсийн хугацаа дууссанаас хойш ажлын 15 өдөрт багтаан үнэлгээ хийж, үнэлгээний дүгнэлтийг гэрээ байгуулах эрх олгох шийдвэрийн саналын хамт Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргад танилцуулна.” гэж, 5.2 дахь хэсгийн “Сонгон шалгаруулалтын явц, үр дүнд үүссэн санал, хүсэлт, гомдол, маргааныг хуулийн хүрээнд шийдвэрлэх” гэж өөрчлөх, мөн журмын 1.2 дахь хэсгийн”Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль” гэснийг, 2.3 дахь хэсгийн 2.3.1 дэх заалтынтөрийн худалдан авах ажиллагааны цахим системд байршуулах” гэснийг, 5.4, 7.1 дэх хэсгийн “....жилд сувилуулах даатгуулагчийн тоо, нийт ор хоног..” гэснийг тус тус хассугай.

2.Тогтоолыг хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар /Б.Батжаргал/-т даалгасугай.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн Ажлын алба /Г.Банзрагч/-нд үүрэг болгосугай.

4.Энэ тогтоолыг 2026 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг